Төрийн нарийн бичгийн даргын
2023 оны 03 дугаар сарын ..09...-ний өдрийн
Б/53.... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төрийн хяналт шалгалтын тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
| Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга | Эрхэлсэн түшмэл, ТЗ-2 |
| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цөмийн болон цацрагийн хяналт шалгалтын бодлого, стратегийг тодорхойлох, хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавих, цөмийн болон цацрагийн болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн
31 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төрийн хяналт шалгалтын тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| | |
|---|---|
| **Байгууллагын нэр:** | **Нэгжийн нэр:** |
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл** |
| Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга | Эрхэлсэн түшмэл, ТЗ-2 |
| **Ажлын цаг** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цөмийн болон цацрагийн хяналт шалгалтын бодлого, стратегийг тодорхойлох, хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавих, цөмийн болон цацрагийн болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Цөмийн энергийн салбарын хяналт шалгалтын бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, нэгдсэн үнэлэлт дүгнэлт өгөх, тайлагнах;
2.Салбарын улсын ерөнхий байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавих, хуульд заасан зөвшөөрөл олгох ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;
3.Нэгжийн үйл ажиллагааг өдөр тутмын нэгдсэн удирдлагаар хангах, албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ өгөх;
4.Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Хяналтын салбарын бодлогыг тодорхойлж, Улсын Их Хурал, Засгийн газар, бодлогын бусад баримт бичигт тусгуулах, шийдвэрлүүлэх ажлыг бодлогын удирдамжаар хангах; | Хяналт шалгалт хийх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна. | Г, Х, Ш |
| | 2.Хяналт шалгалтын үр дүнд нэгдсэн үнэлэлт дүгнэлт гаргах, цаашдын хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах; | Салбарын хяналт шалгалтын ажлыг бодитой төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлсэн байна. | Г, Х, Ш |
| | 3.Олон улсын байгууллагуудтай зохих журмын дагуу хамтран ажиллах, төсөл хөтөлбөрт хамрагдах, хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; | Олон улсын жишигт нийцсэн хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна. | Г, Х, Ш |
| | 4.Цөмийн болон цацрагийн ослоос хамгаалах, хариу арга хэмжээний үед мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран ажиллах бодлогыг тодорхойлох; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х, Ш |
| | 5.Цаг үеийн шинжтэй онцгой нөхцөл байдалд албан хаагчдыг удирдлага, зохион байгуулалтаар хангах. | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х, Ш |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Салбарын улсын ерөнхий байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах, хяналт шалгалтын баримт бичгийг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх; | Хяналт шалгалтыг бүрэн гүйцэт хийсэн байна. | Г, Х, Ш |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг батлах; | Хяналт шалгалтын удирдамжаар хангагдсан байна. | Х, Ш |
| | 3.Холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х, Ш |
| | 4.Хяналтын хуудас, эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх, хяналт шалгалт хийх объектыг хуульд заасан хугацаанд олон нийтэд зарлуулах ажлыг удирдан зохион байгуулах; | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Г, Х, Ш |
| | 5.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; | Аюулгүй байдлыг хангуулж, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Г, Х, Ш |
| | 6.Улсын (ахлах) байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг шийдвэрлэх; | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Г, Х, Ш |
| | 7.Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, экспортлох, импортлох, тээвэрлэх, цацраг идэвхт хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээхэд салбарын улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрөл олгох; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Х, Ш |
| | 8.Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтлөх мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; | Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. | Г, Х, Ш |
| | 9.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдлагаар хангах; | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулсан байна. | Х, Ш |
| | 10.Салбарын улсын ерөнхий байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. | Г, Х, Ш |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Нэгжийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд бодлогын чиглэл өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх, манлайлах; | Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна. | Г, Х, Ш |
| | 2.Улсын /ахлах/ байцаагчидтай гүйцэтгэлийн гэрээ байгуулах, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, тайлагнах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; | | Г, Х, Ш |
| | 3.Нэгжийн үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг удирдлагаар хангах; | Олон нийтэд сурталчилсан байна. | Г, Х, Ш |
| | 4.Засгийн газар, удирдах дээд албан тушаалтныг болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах; | Үнэн зөв, бодитой мэдээллээр хангасан байна. | Г, Х, Ш |
| | 5.Цөмийн энергийн тухай хуулийн 18.8 дахь заалтын дагуу холбогдох санал өгөх ажлыг удирдан зохион байгуулах; | Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. | Г, Х |
| | 6.Нэгжийн албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судалж, шийдвэрлэлтэд хяналт тавих; | Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. | Г, Х, Ш |
| | 7.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх салбарын албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах; | Салбарын хүний нөөцийн чадамж дээшилсэн байна. | Г, Х, Ш |
| | 8.Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; | Хамтын ажиллагаа өргөжсөн байна. | Г, Х |
| | 9.Иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангах, хяналт шалгалтын чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, семинар удирдан зохион байгуулах; | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна. | Г, Х, Ш |
| | 10.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлэх, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах. | Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна. | Г |

| | | | |
|---|---|---|---|
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна. | Г |
| | 2.Яамны удирдлага, бусад нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх; | Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна. | Г |
| | 3.Холбогдох асуудлаар ажлын хэсэг, комисс, тендерийн болон стандартчиллын техникийн хороо зэрэгт ажиллах; | Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. | Г |
| | 4.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөх; | Мөрдсөн байна. | Г |
| | 5.Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн шагнал, урамшуулалд тодорхойлох; | Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. | Г, Ш |
| | 6.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; | Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлсэн байна. | Г |
| | 7.Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; | Идэвхтэй оролцсон байна. | Г |
| | 8.Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг маягтын дагуу мэдээлэх. | Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв, хугацаанд нь гаргасан байна. | Г, Х |

| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | |
|---|---|
| Боловсрол | Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | -физик /053301/;<br>-цөмийн физик /053305/;<br>-цөмийн инженерчлэл /071312/;<br>-цөмийн технологи /071313/;<br>-электроникийн инженерчлэл /071401/. |
| Мэргэшил | Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх. |

МОНГОЛ УЛС ЗОВШООРОВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| Туршлага | Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, эрх зүйн орчныг бүрдүүлэх;<br>- салбарын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөмж, зөвлөгөө өгөх;<br>- салбарын эрсдэлийн удирдлагын дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх бодлого, төлөвлөлт тодорхойлох; үр дүнтэй хэрэгжүүлэх;<br>- нэгжийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамт олныг чиглүүлж, үр дүнд хүргэх;<br>- нэгжийн үйл ажиллагааны ил тод, шуурхай, хариуцлагатай байдлыг хангах;<br>- нэгжийн албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, мэргэжлийн зөвлөгөө өгч удирдан чиглүүлэх, хариуцлага тооцох;<br>- албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;<br>- албан хаагчдын сургалт хөгжлийн асуудалд идэвхтэй дэмжлэг үзүүлж, тасралтгүй суралцагч байгууллага болох соёлыг төлөвшүүлэх;<br>- бусад. |
| | Дүн шинжилгээ хийх | - салбарын бодлого, төлөвлөлтийн аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх, уялдуулан зохицуулах;<br>- салбарын хөгжлийн чиг хандлагыг судалж, хяналтын чиг үүргийг боловсронгуй болгох;<br>- салбарын хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;<br>- бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах;<br>- хяналтын чиглэлээр боловсруулсан бодлогыг нэгтгэх, уялдааг хангах, хэрэгжилтийг зохицуулах;<br>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;<br>- салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; салбарын хяналтын чиглэлээр тулгамдаж буй асуудлыг судлах, дээд шатны удирдлагад танилцуулах;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;<br>- хяналт шалгалттай холбоотой аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах, шийдвэрлүүлэх;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; |

| | | |
|---|---|---|
| | | - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах;<br>- бусад. |
| | Манлайлах | - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанарыг эрхэмлэж, өөрийн үйл хөдлөл, бие авч яваа байдлаар бусдад зөв үлгэр дуурайл үзүүлэх;<br>- мэдлэг, ур чадвар, ажил хариуцах байдлаар хамт олондоо хүлээн зөвшөөрөгдөх;<br>- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үйл явцыг манлайлж, хамт олны оролцоог хангах<br>- харилцааны өндөр соёлтой байх;<br>- зөрчилдөөнийг эв дүйгээр зохицуулах;<br>- зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;<br>- шинэлэг санаа дэвшилтэт арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачлага, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих;<br>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;<br>- нээлттэй, шударга байх;<br>- ажлын шинэ арга барилыг нэвтрүүлж, хөгжүүлэх, бүтээлч, санаачлагатай ажиллах;<br>- өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах;<br>- хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;<br>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах;<br>- нэгжийн зорилтыг тодорхойлохдоо хамт олны оролцоог хангах, санал авах, тусгах;<br>- бусад. |
| | Бусад | - хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцахярианы ур чадвар эзэмшсэн байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;<br>- төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;<br>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;<br>- албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах;<br>- жендерийн тэгш байдлыг хангаж ажиллах. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<u>Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:</u>
Төрийн нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | |
|---|---|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>-шинжээч - 1<br>-ахлах мэргэжилтэн - 10<br>Нийт: 11 | Бусад харилцах субъект:<br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага;<br>- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br>................................................ / /<br>2023 оны 03 сарын 09-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 23 0201<br>Дугаар: 031 |

## VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Шийдвэрийн огноо: 2023.03.09

Дугаар: Б/53

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ........................................ Л.ЦЭДЭВСҮРЭН

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр